



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Д.ДЭЛГЭРСАЙХАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381

Утас/Факс: (976-51) 26 23 50,

Цахим шуудан: info@pcsp.gov.mn,

Цахим хуудас: www.pcsp.gov.mn

2023.01.19

№ А-1/126

танай _____-НЫ № _____-Т

**Хөрөнгө бүртгэх, данс хооронд
шилжүүлэх тухай**

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2022 оны 3/6135 дугаар албан бичгээр уламжлан ирүүлсэн данс хооронд хөрөнгө шилжүүлэх, бүртгэх, акталж, данснаас хасах зөвшөөрөл хүссэн албан бичигтэй танилцаад дараах зөвшөөрлийг өгч байна. Үүнд:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.1, 4.10, 5.1 дэх заалтыг үндэслэн Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны дэмжлэгтэйгээр Улсын бүртгэлийн ерөнхий газарт хэрэгжсэн "Нийгмийн үйлчилгээний дэмжлэгтэйгээр сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох" төслийн хүрээнд нийлүүлэгдсэн хөрөнгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын данс бүртгэлд бүртгэх;

2.Баянхонгор, Баян-Өлгий аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг Баянхонгор, Баян-Өлгий аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн данс бүртгэлд тусгах;

3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 2.2 дахь заалтын дагуу Орхон аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 5 нэрийн, нийт 3,529,900.00 (гурван сая таван зуун хорин есөн мянга есөн зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу дансны ангилал хооронд шилжүүлэн бүртгэхийг тус тус зөвшөөрч байна.

Сүхбаатар аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга байгууламжийг акталж, данснаас хасахад тухайн газрыг цаашид ашиглах зориулалтыг тодорхой болгон холбогдох баримтыг бүрдүүлэн дахин хандах, цаашид хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн зөв ангилан бүртгэж байх нь зүйтэй.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

A-4/2022

132012064

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн
А-1/126 дугаар албан бичгийн хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ОРХОН АЙМАГ ДАХЬ УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮНДСЭН
ХӨРӨНГӨД ШИЛЖҮҮЛЭН БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Ариутгалын шүршигч машин	1/1/2021	ш	1	450,000.00	450,000.00
2	Гар ариутгагч төхөөрөмж	1/1/2020	ш	1	240,000.00	240,000.00
3	Тасалгааны цэвэрлэгч хэрэгслийн багц	1/1/2021	ш	1	1,040,000.00	1,040,000.00
4	Ус шүүгч	1/1/2019	ком	1	870,000.00	870,000.00
5	Ус шүүгч	1/1/2020	ш	1	929,900.00	929,900.00
ДҮН						3,529,900.00